


БАТЛАВ.  
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА



Г.ЧИНЗОРИГ

2021 оны 09 сарын 10-ны өдөр

БАТЛАВ  
"БИ АР БИ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ



Ж.ЭНХЖАРГАЛАН

УЛААНБААТАР ХОТ  
111624205 ☎ 5681665

№ 18/2101

Улаанбаатар хот.

## ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ

### Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү түрээсийн гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г нэг талаас "ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО" (цаашид түрээслэгч гэх) түүнийг төлөөлж Захиргааны Удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга З.Эрдэнэчулуун, нөгөө талаас "БИ АР БИ" ХХК /регистрийн дугаар №6081665, улсын бүртгэлийн дугаар №9011618033/ (цаашид түрээслүүлэгч гэх), түүнийг төлөөлж Арга хэмжээ хариуцсан менежер Т.Гэсэр нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) Иргэний хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засаг үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн дараах болзол, нөхцөлийг харилцан тохиролцож 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр байгуулав.

1.2.Түрээслүүлэгч, түрээслэгч нар нь Монгол улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль бусад мөрдөгдөж буй хуулиудын өмчийн харилцааны холбогдолтой заалт, удирдах дээд байгууллагаас гаргасан шийдвэр, журам, дүрмийг мөрдлөг болгон ажиллана.

1.3.Энэхүү гэрээгээр Харилцаа холбооны салбарын Улсын зөвлөгөөн арга хэмжээнд шаардлагатай нэмэлт тоног төхөөрөмж, дэлгэцийг 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн 2021 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийг дуусгавар болох хүртэл хугацаатайгаар түрээсээр эзэмшүүлэхээр тохиролцов.

1.4 Гэрээний төлбөр 9,800,000 /есөн сая найман зуун мянган/ төгрөг байна. Энэ үнэд НӨАТ орсон болно.

1.5 Захиалагч нь уг гэрээний 2.1 дэх хэсэгт заасан ажлын 100 хувийн төлбөр болох 9,800,000 /есөн сая найман зуун мянга/ төгрөгийг ажил гүйцэтгэгчээс ирүүлсэн нэхэмжлэхийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан шилжүүлнэ.

1.6 Гэрээний төлбөрийг хүлээн авах дансны мэдээлэл:



a	Гэрээний төлбөр	9,800,000
b	Хүлээн авагчийн нэр	"БИ АР БИ" ХХК
c	Хүлээн авах банк	Голомт банк
d	Дансны дугаар	1415108096
e	Валют	MNT

### Хоёр.Түрээслүүлэгчийн эрх, үүрэг

2.1.Түрээслүүлсэн хөрөнгийн ашиглалтын байдалд хяналт тавьж, ашиглалтын үйл ажиллагааны талаар дүгнэлт гаргах, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчин хөрөнгийг зориулалт бусаар ашиглавал түрээсийн гэрээг цуцалж, түрээслүүлсэн хөрөнгийг эргүүлж авна.

2.2.Түрээслэгч гэрээний үүргээ хэрхэн биелүүлж байгаа болон дэлгэцийн ашиглалт, гарсан доголдлыг арилгуулах шаардлага тавих, шаардлагатай гэж үзвэл үйлчилгээг тодорхой хугацаагаар сунгах зэрэг арга хэмжээг авах эрхтэй.

2.4.Түрээслэгчийн үйл ажиллагаанаас хамаарч түрээслүүлэгч талд хохирол учруулбал түрээслүүлсэн хөрөнгийг буцаан авч холбогдох төлбөр тогтоон, гарсан хохирлыг нэхэмжилж нөхөн төлүүлнэ.

2.5.Эрх бүхий төр, захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр зориулалтын бус үйлдвэрлэл үйлчилгээ явуулах, түрээсийн төлбөрөө хугацаанд нь төлөөгүй тохиолдолд уг үйлчилгээг таслан зогсоож гэрээнд заасан арга хэмжээ авна.

2.6.Түрээслэгчээс хөрөнгийн ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх талаар авч хэрэгжүүлэх идэвхтэй үйл ажиллагааг дэмжинэ.

2.10. Гэрээг түрээслүүлэгчид урьдчилан мэдэгдэлгүйгээр түрээслэгч талын санаачилгаар хугацаанаас өмнө цуцалсан тохиолдолд түрээслүүлэгчид учирсан хохирлыг нэхэмжлэх эрхтэй.

2.11. Түрээслэж байгаа тоног төхөөрөмж, дэлгэцийн хэвийн, найдвартай ажиллагааг бүрэн хангаж ажиллана.

### Гурав. Түрээслэгчийн эрх, үүрэг

3.1.Түрээслэсэн хөрөнгийн эдэлгээ, ашиглалтын горимыг чанд мөрдөн ариг гамтай эдлэх, гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглах, зүй бусаар элэгдэл гэмтэлд оруулахгүй байх, хэрэв ямар нэг гэмтэл учруулсан бол нөхөн сэргээх үүрэг хүлээнэ.

3.2.Түрээслэгч ашиглалтын үйл ажиллагаатай холбогдсон бүх зардлыг хариуцна. Энэ тухайд түрээслүүлэгчээс ямарваа хөрөнгө шаардахгүй.

3.3.Түрээслэгч түрээслүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр түрээслэн авсан хөрөнгөд өөрчлөлт оруулах, хөрөнгө оруулалт хийх, барилгад өргөтгөл шинэтгэл хийхийг хориглоно.

3.4.Түрээслэгч нь түрээслэсэн эд хөрөнгийг барьцаалах, түүгээр баталгаа гаргахыг хориглоно.

3.5.Түрээсийн гэрээг цуцлах үед түрээслэж авсан дэлгэцийг анх хүлээлцсэнээс чанарын хувьд муудаж, эвдэрсэн нь түрээслэгчийн буруутай үйл ажиллагаанаас



болсон нь тогтоогдсон бол дэлгэцийн хэвийн ажиллагаанд гэрээний хугацаанд байнга хяналт тавьж, гарсан доголдлыг шуурхай арилгах арга хэмжээг авах үүрэгтэй. 3.6.Түрээсийн төлбөрийг хугацаанд нь төлөх, гэрээний хугацаа дууссаны дараа хөрөнгийг түрээслүүлэгчид актаар хүлээлгэн өгөх үүрэгтэй.

#### **Дөрөв. Гэрээ цуцлах тухай**

4.1.Доорхи тохиолдолд түрээслүүлэгч гарсан хохирлыг түрээслэгчээр төлүүлэн гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:

-түрээсийн төлбөрөө хожимдуулан төлөх

-түрээслэгч нь дэлгэцийг ашиглахдаа түрээслүүлэгчийн зөвшөөрөлгүй дур мэдэн өөрчлөх

-зохих зөвшөөрөлгүй давхар түрээслэх зэрэг гэрээний үүргээ ноцтой зөрчих

- эд хөрөнгөнд ноцтой хохирол учруулах

-хуульд болон гэрээнд заасан бусад нөхцөлийг зөрчих

4.2.Төр засгийн эрх бүхий дээд байгууллагаас тухайн эд хөрөнгийг өөр байгууллагад шилжүүлэх, хувьчлах шийдвэр гаргах үед гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгоно.

4.3.Талууд гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгох, өөрчлөлт оруулах тухай саналаа нөгөө талд 14 хоногоос доошгүй хоногийн өмнө мэдэгдэж хамтран шийдвэрлэнэ. Энэ хооронд нөгөө талаас хариу ирүүлээгүй нөхцөлд гэрээг дуусгавар болгож цуцалсанд тооцно.

#### **Тав. Бусад зүйл**

5.1.Гэрээтэй холбогдон гарсан аливаа асуудлыг талууд нөхөрсгөөр шийдвэрлэх ба харилцан тохиролцоогүй асуудлыг шүүхээр шийдвэрлүүлнэ.

5.2.Түрээсийн гэрээг жил бүрийн эцэст хоёр тал харилцан дүгнэж цаашид гэрээг сунгах эсэх, түрээсийн төлбөрийг шинэчлэн тогтоох, түрээсийн харилцаатай холбоотой шинээр гарсан шийдвэр, хууль тогтоомжийн дагуу зарим заалтанд өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг хэлэлцэн протокол үйлдэж байна.

5.3.Энэхүү гэрээнд заагдаагүй бусад асуудлыг энэ гэрээг байгуулах үед мөрдөж байсан Монгол улсын хууль тогтоомжийн бусад актаар зохицуулна.

#### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

БАТЛАВ.

**“ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО”-Г ТӨЛӨӨЛЖ:**

Захиргааны Удирдлага, Хамтын  
ажиллагааны газрын дарга

З.ЭРДЭНЭЧУЛУУН




БАТЛАВ.


**АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
“БИ АР БИ” ХХК-ийн**

Арга хэмжээ хариуцсан менежер

Т.ГЭСЭР



Хуулийн хэлтсийн дарга



Т.УУГАНБАТ

Захиргааны Удирдлага, Хамтын  
ажиллагааны газрын мэргэжилтэн



Д.НАРАНСОЛОНГО

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛ  
ХЯНАВ  
Гарын үсэг:   
20...01...09...01